



МОНГОЛ УЛС  
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,  
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,  
E-mail: comcor@iaac.mn, http://iaac.mn

ГЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН  
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ  
Р.МЭРГЭН ТАНАА

2018.09.18. № 05/7557  
танай 2018.09.07 ны № 031435/03/577  
10

Г Хувийн ашиг сонирхлын урьдчилсан  
мэдүүлгийг хянасан тухай

Зам, тээврийн хөгжлийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын төмөр замын салбарын бодлого, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтнээр томилогдоо нэр дэвшсэн Лхамрагчаагийн Булганхүү, Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын улс хоорондын тээвэр хариуцсан мэргэжилтнээр томилогдоо нэр дэвшсэн Загдгочоогийн Бүжинлхам нарын хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгийг Нийтийн албанад нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6 дахь хэсэгт заасныг үндэслэн хянан үзэхэд тухайн албан тушаалд томилоход ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал одоогоор тогтоогдоогүй болно.

Нэр дэвшигч нар нь тухайн албан үүргийг гүйцэтгэхэд ашиг сонирхлын зөрчил үүссэн, үүсч болзошгүй нөхцөл байдалд дээрх хуулийн 8 дугаар зүйлд заасан мэдэгдэл, тайлбарыг тухай бүр гаргаж байх, мөн хуульд заасан бусад хориглолт хязгаарлалтыг хэрэгжүүлж, уг албан тушаалд томилогдсоны дараа хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ хуульд заасан хугацаанд холбогдох байгууллагын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтанд цахимаар мэдүүлэх үүрэгтэй болохыг анхаарна уу.

ХЯНАЛТ ШАЛГАЛТ, ДҮН  
ШИНЖИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  
ЭРХЭЛСЭН КОМИССАР

Х.ХАШБААТАР

178830216436373

0012804